

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

**ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2019 ОН

20



1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2019 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжил хурлаас гадна ээлжит бус хурлыг 2 удаа зарлаж Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хуралдуулсан. Тайлант хугацаанд Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд томоохон өөрчлөлт орж 2019 оны 7 сарын 1 ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Компанийн оноосон нэрийг өөрчилж, дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан. Холбогдох журмын дагуу Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтээ илгээж, зөвшөөрсөн тухай МХБ-ийн захирлын тушаал 2019 оны 8 сарын 20-ны өдөр, СЗХ-ны даргын тушаал 2019 оны 11 сарын 13-ний өдөр тус тус гарсан. Ийнхүү Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газар бүртгэлийг шинэчлэн баталгаажуулсан болно. Улмаар Татварын Ерөнхий Газар, харьяа дүүргийн Төрийн Сангийн Хэлтэс зэрэг байгууллагад бүртгэлд өөрчлөлт оруулсан тухай баримт бичгүүдийг хүргүүлж холбогдох мэдээллийг шинэчилсэн. Компанийг шинээр зохион байгуулах ажилд хугацаа их зарцуулагдаж оны эцэст хүрсэн тул төлөвлөж байсан ажлууд хойшлогдож үйл ажиллагаа жигдрээгүй болно.

2. КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл тайлант хугацаанд улирал тутамд хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гаргасан. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлд дараах гишүүд ажиллаж байна.

1. П.Очирхуяг (хараат гишүүн)
2. Ц. Оюунтуяа (хараат гишүүн)
3. Б. Отгонбаатар (хараат гишүүн)
4. Yeh Montgomer (хараат гишүүн)
5. Lin Yu Fei (хараат гишүүн)
6. He Shanjun (хараат гишүүн)
7. Tsai Chin-kun (хараат бус гишүүн)
8. Ku Cheng-Chuan (хараат бус гишүүн)
9. Shih Pei Chih (хараат бус гишүүн)

Компанийн тухай хуулийн 81.2 дах хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах байдлаар байгуулсан.

Аудитын хороо :

Дарга	Tsai Chin Kun / хараат бус /
Гишүүд	Shih Pei Chih / хараат бус /
	Yeh Montgomer / хараат бус /
	Lin Yu-Fei
	Б. Отгонбаатар

Цалин урамшуулал хороо :

Дарга	Lin Yu-Fei
Гишүүд	Tsai Chin-Kun / хараат бус /
	Ku-Cheng-Chuan / хараат бус /


Нэр дэвшүүлэх хороо :

Дарга Yeh Montgomer / хараат бус /

Гишүүд Tsai Chin-Kun / хараат бус /

Shih Pei Chih



Гүйцэтгэх удирдлагын баг дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн байдлын хувьд 2019 онд хурал зохион байгуулахтай холбоотой зардлууд гарсныг эс тооцвол үйл ажиллагаа явуулаагүй болохоор санхүүгийн тайланд төдийлөн өөрчлөлт ороогүй. Харин эздийн өмчийн хэсэгт дүрмээс зөрүүтэй хэсэг байсныг аудитын компанийн зөвлөмжийн дагуу засч, залруулж, тодруулга хийв. Өнгөрсөн оны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангууд гарч холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлж баталгаажуулсан.

"Глобал лайф технологи" ХК		
2019 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн тодруулга		
	2018	2019
3. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
Кассанд байгаа бэлэн мөнгө/төгрөг/	4,264,600	61,780
Харилцахад байгаа бэлэн мөнгө /төгрөг/		
	4,264,600	61,780
4. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО	2018	2019
Урьдчилж гарсан зардал	39,600	39,600
Урьдчилж гарсан тооцоо		
	39,600	39,600
5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2018	2019
Тээврийн хэрэгсэл		
Тавилга эд хогшил	6,670,000	6,670,000
Компьютер бусад хэрэгсэл		
Бусад үндсэн хөрөнгө		
	6,670,000	6,670,000
Хуримтлагдсан элэгдэл		
Тээврийн хэрэгсэл		
Тавилга, эд хогшил		
Компьютер бусад хэрэгсэл		
Бусад үндсэн хөрөнгө		
	-	-
6. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	2018	2019
Дансны өглөг	-	2,000,000
	-	2,000,000

6. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	2018	2019
Дансны өглөг	-	2,000,000
	<u>-</u>	<u>2,000,000</u>
7 ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	2018	2019
Энгийн хувьцаа	34,853,900	7,215,700
Эздийн өмчийн бусад хэсэг		27,638,200
	<u>34,853,900</u>	<u>34,853,900</u>
8. ХУРИМТЛАГДСАН АШИГ	2018	2019
Тайлант үеийн ашиг / алдагдал /	(23,879,700)	(6,202,820)
Өмнөх үеийн ашиг / алдагдал /		(23,879,700)
	<u>(23,879,700)</u>	<u>(30,082,520)</u>
9. БОРЛУУЛАЛТ БА ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДЛУУД	2018	2019
Ажиллагчдын цалингийн зардал		
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал		
Бичиг хэргийн зардал		758,260
Шуудан холбооны зардал		
Мэргэжлийн үйлчилгээний зардал		
Сургалтын зардал		2,025,000
Бусад зардал		3,419,560
	<u>-</u>	<u>6,202,820</u>
Аудитор		Ч.Эрдэнэжав
		

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2019 оны 4 сарын 19 ний өдрийн Монголын хөрөнгийн биржийн багцын арилжаагаар Компанийн хяналтын багцыг буюу 89.6 хувийг Хөхөө агротех ХХК худалдан авсан. Компанийн тухай хуулийн 57.1 д заасан худалдан авах санал гаргах үүргийн дагуу Компанийн хувьцааг худалдан авах тендер саналыг хяналтын багц эзэмшигч 2019 оны 4 сарын 29 –ний өдрөөс 5 дугаар сарын 29 ны өдрийг хүртэл зарласан. Энэ хугацаанд хувьцаагаа худалдах санал ирээгүй. Харин 2019 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хувьцааны багцын арилжаагаар Еэ Монтгомер 64,661 ширхэг хувьцааг худалдан авсныг СЗХ-ны “Мэдээлэлийн ил тод байдлын тухай журам”-ын дагуу хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн мэдээллийг 2019 оны 8 дугаар сарын 12 ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргэсэн билээ. Ийнхүү тус компанийн 89.6 хувийг Еэ Монтгомер дангаар эзэмших болсон тул Компанийн тухай хуулийн 57.1 болон СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-ыг үндэслэн үүргээ хэрэгжүүлэхээр хувьцааг худалдан авах саналыг 2019 оны 8 дугаар сарын 12 ны өдөр гаргасан. 2019 оны 9 дүгээр сарын 16 ны өдөр уг саналын хугацаа дууссан ба энэ хугацаанд хувьцаагаа худалдах санал ирээгүй болно. 2019 оны эцсийн байдлаар нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн жагсаалт дараах байдалтай байна.

Нэр	Хувьцааны тоо	Хувь
He Shanjun	3,608	5.0
Ц. Отгонтуяа	3,608	5.0
Yeh Montgomer	64,661	89.6

5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 46.8 дах хэсэгт заасан шалгуурыг хангаагүй буюу тайлант хугацаанд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар 2020 оны 2 дугаар сарын 14 ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн.